



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онон-Улз голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/111/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Гэрээт аудитор: Б.Оюунхэрлэн

Утас: 7058-4204, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт	13
Залруулсан алдаа	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 138

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндун сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онон-Улз голын сав газрын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Онон-Улз голын сав газрын захиргаа 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 82.2 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011021257



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,014,633.00	13,011,218.90
33	АВЛАГА	3,443,200.00	3,649,955.90
335	Бусад авлага	3,443,200.00	3,649,955.90
3351	Байгууллагаас авах авлага	3,443,200.00	3,649,955.90
35	БАРАА МАТЕРИАЛ	8,571,433.00	9,361,263.00
351	Түүхий эд материал	4,049,250.00	5,836,350.00
35110	Тусгай зориулалттай материал	4,049,250.00	5,836,350.00
354	Хангамжийн материал	4,522,183.00	3,524,913.00
35410	Бичиг хэргийн материал	723,370.00	1,138,400.00
35420	Аж ахуйн материал	2,475,813.00	2,386,513.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	74,823,032.71	67,022,941.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	74,823,032.71	67,022,941.94
392	Биет хөрөнгө	68,823,032.71	61,022,941.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	63,125,151.00	63,125,151.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-4,208,343.36	-4,734,386.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	27,760,250.00	29,719,750.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-25,206,475.26	-27,760,250.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,146,407.42	32,146,407.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	-28,524,779.48	-31,473,730.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,381,980.13	8,381,980.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,651,157.74	-8,381,980.13
393	Биет бус хөрөнгө	6,000,000.00	6,000,000.00
39301	Програм хангамж	1,540,000.00	1,540,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,540,000.00	-1,540,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,000,000.00	6,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	86,837,665.71	80,034,160.84
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,886,653.07
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,886,653.07
413	Өглөг	00.00	2,886,653.07
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	2,331,368.53
4136	Бусад өглөг	00.00	555,284.54
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	555,284.54
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	86,837,665.71	77,147,507.77
51	Засгийн газрын хувь оролцоо	86,837,665.71	77,147,507.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	214,914,999.51	214,914,999.51
51101	Өмч: - төрийн	214,914,999.51	214,914,999.51
512	Хуримтлагдсан үр дүн	-128,077,333.80	-137,767,491.74
51210	Өмнөх үеийн үр дүн	-128,077,333.80	-128,077,333.80
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-9,690,157.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	86,837,665.71	80,034,160.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	157,344,900.00	198,726,296.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,959,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	1,959,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,959,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	1,959,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	157,344,900.00	196,766,796.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	157,344,900.00	186,721,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	157,344,900.00	186,721,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	10,044,996.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив	00.00	1,330,710.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	714,286.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	8,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	180,851,703.00	208,416,453.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	180,851,703.00	208,416,453.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	177,765,462.38	201,891,673.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,025,394.16	133,279,776.17
210101	Үндсэн цалин	77,857,700.00	85,087,476.17
210102	Нэмэгдэл	31,132,494.16	42,181,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,035,200.00	6,011,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,490,800.22	17,754,924.48
210201	Тэтгэврийн даатгал	10,003,581.07	12,499,765.11
210202	Тэтгэмжийн даатгал	1,148,657.84	1,316,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	918,927.03	1,052,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	219,968.80	253,759.37
210205	Эрүүл мэндийн даатгал	2,199,665.48	2,632,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,345,231.00	18,538,142.75
210301	Гэрэл, цахилгаан	5,593,500.00	4,868,179.65
210302	Түлш, халаалт	405,731.00	7,918,700.00
210304	Байрны түрээс	5,346,000.00	5,751,263.10
2104	Хангамж, бараа материалын зардал	16,799,746.00	6,644,546.00
210401	Бичиг хэрэг	2,582,280.00	945,120.00
210402	Тээвэр, шатахуун	8,474,890.00	4,091,696.00
210403	Шүүдэн, холбоо, ингэрнэгийн төлбөр	993,790.00	1,154,380.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,748,786.00	453,350.00
2105	Нормативт зардал	62,450.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	62,450.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	255,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	255,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,381,510.00	8,489,700.00
210702	Дотоод албан томилолт	3,381,510.00	8,489,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,399,944.00	6,922,493.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	618,700.00	6,341,751.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	268,000.00	180,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	117,900.00	102,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,092.00	133,742.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	236,500.00	165,000.00
210807	Газрын төлбөр	22,152.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,260,387.00	10,007,090.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,164,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	995,000.00	247,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,101,387.00	9,759,590.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,086,240.62	6,524,780.77
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,086,240.62	6,524,780.77
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,086,240.62	6,524,780.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-23,506,803.00	-9,690,157.94
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-23,506,803.00	-9,690,157.94

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	168,266,186.00	196,766,796.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	168,266,186.00	196,766,796.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	157,344,900.00	186,721,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	157,344,900.00	186,721,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,921,286.00	10,044,996.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,921,286.00	1,330,710.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	714,286.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	8,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	168,266,185.97	196,766,796.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	168,266,185.97	196,766,796.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	165,179,945.35	190,242,015.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,025,394.16	131,452,700.00
210101	Үндсэн цалин	77,857,700.00	83,260,400.00
210102	Нэмэгдэл	31,132,494.16	42,181,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,035,200.00	6,011,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,490,800.19	17,754,924.48
210201	Тэтгэврийн даатгал	10,003,581.07	12,499,765.11
210202	Тэтгэмжийн даатгал	1,148,657.84	1,316,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	918,927.00	1,052,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	219,968.80	253,759.37
210205	Эрүүл мэндийн даатгал	2,199,665.48	2,632,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,668,231.00	12,677,642.75
210301	Гэрэл, цахилгаан	5,346,000.00	4,868,179.65
210302	Түлш, халаалт	1,976,231.00	2,058,200.00
210304	Байрны түрээс	5,346,000.00	5,751,263.10
2104	Хангамж, бараа материалын зардал	15,074,166.00	12,570,476.00
210401	Бичиг хэрэг	2,410,300.00	1,333,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,199,890.00	8,629,196.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	993,790.00	1,481,530.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,470,186.00	1,126,750.00
2105	Нормативт зардал	624,500.00	624,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	624,500.00	624,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	356,400.00	355,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	356,400.00	355,000.00
2107	Томилголт, зочны зардал	3,381,510.00	8,489,700.00
210702	Дотоод албан томилолт	3,381,510.00	8,489,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,399,944.00	6,069,672.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	618,700.00	5,488,930.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	268,000.00	180,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	117,900.00	102,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	97,092.00	133,742.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	236,500.00	165,000.00
210807	Газрын төлбөр	22,152.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,159,000.00	247,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,164,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	995,000.00	247,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,086,240.62	6,524,780.77
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,086,240.62	6,524,780.77
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,086,240.62	6,524,780.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.03	0.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.03	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.03	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,914,999.51	00.00	214,914,999.51
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	-23,506,803.00	-23,506,803.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,914,999.51	-128,077,333.80	86,837,665.71
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,914,999.51	-128,077,333.80	86,837,665.71
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	214,914,999.51	-128,077,333.80	86,837,665.71
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	-9,690,157.94	-9,690,157.94
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,914,999.51	-137,767,491.74	77,147,507.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	157,344,900.00	154,258,659.38	186,721,800.00	186,721,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	157,344,900.00	154,258,659.38	186,721,800.00	186,721,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	157,344,900.00	154,258,659.38	186,721,800.00	186,721,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл үрамшил	115,278,300.00	115,025,394.16	131,616,300.00	131,452,700.00
210101	Үндсэн цалин	77,857,700.00	77,857,700.00	83,260,400.00	83,260,400.00
210102	Нэмэгдэл	31,246,000.00	31,132,494.16	42,181,300.00	42,181,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,174,600.00	6,035,200.00	6,174,600.00	6,011,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,353,600.00	14,490,800.22	17,768,100.00	17,754,924.48
210201	Тэтгэврийн даатгал	10,440,400.00	10,003,581.07	12,503,500.00	12,499,765.11
210202	Тэтгэмжийн даатгал	1,228,300.00	1,148,657.84	1,316,100.00	1,316,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	982,600.00	918,927.03	1,052,900.00	1,052,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	245,700.00	219,968.80	263,200.00	253,759.37
210205	Эрүүл мэндийн даатгал	2,456,600.00	2,199,665.48	2,632,400.00	2,632,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,672,000.00	12,668,231.00	13,155,500.00	12,677,642.75
210301	Гэрэл, цахилгаан	5,346,000.00	5,346,000.00	5,346,000.00	4,868,179.65
210302	Тулш, халаалт	1,980,000.00	1,976,231.00	2,058,200.00	2,058,200.00
210304	Байрны түрээс	5,346,000.00	5,346,000.00	5,751,300.00	5,751,263.10
2104	Хангамж, бараа материалын зардал	6,638,900.00	6,638,890.00	7,951,000.00	7,859,680.00
210401	Бичиг хэрэг	963,300.00	963,300.00	713,900.00	713,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,554,900.00	3,554,900.00	4,627,500.00	4,537,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	993,800.00	993,790.00	1,482,700.00	1,481,530.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,126,900.00	1,126,900.00	1,126,900.00	1,126,750.00
2105	Нормативт зардал	624,500.00	624,500.00	624,500.00	624,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	624,500.00	624,500.00	624,500.00	624,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	356,400.00	356,400.00	356,400.00	355,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	356,400.00	356,400.00	356,400.00	355,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,562,700.00	2,559,500.00	3,172,500.00	3,155,500.00
210702	Дотоод албан томилолт	2,562,700.00	2,559,500.00	3,172,500.00	3,155,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,363,500.00	1,399,944.00	11,908,600.00	6,069,672.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,475,000.00	618,700.00	11,020,100.00	5,488,930.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	297,000.00	268,000.00	297,000.00	180,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,600.00	117,900.00	138,600.00	102,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	138,600.00	97,092.00	138,600.00	133,742.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	39,600.00	39,600.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	236,500.00	250,000.00	165,000.00
210807	Газрын төлбөр	24,700.00	22,152.00	24,700.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	495,000.00	495,000.00	348,900.00	247,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	495,000.00	495,000.00	348,900.00	247,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,086,240.82		6,524,780.77
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	157,344,900.00	154,258,659.38	186,721,800.00	186,721,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	157,344,900.00	154,258,659.38	186,721,800.00	186,721,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	157,344,900.00	154,258,659.38	186,721,800.00	186,721,800.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
620001	Удирдах ажилтан	01.00	01.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00		
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		10,044,996.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		10,044,996.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		10,044,996.00
2104	Хангамж, бараа материалын зардал		4,710,796.00
210401	Бичиг хэрэг		619,100.00
210402	Тээвэр, шатахуун		4,091,696.00
2107	Томилолт, зочны зардал		5,334,200.00
210701	Гадаад албан томилолт		00.00
210702	Дотоод албан томилолт		5,334,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		10044996.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		10,044,996.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,330,710.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		714,286.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		8,000,000.00
131106	Төсвийн урамшуулал		00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Онон-Улз голын сав газрын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Б.Баяртогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 29-ноос 2021 оны 02 дугаар сарын 23-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Б.Оюунхэрлэн хариуцаж хэрэгжүүлэв.

Онон-Улз голын сав газрын захиргаа 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 12 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Онон-Улз голын сав газрын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сав газарт усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдмэл удирдлагаар хангах төрийн үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Онон-Улз голын сав газрын захиргаа нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Онон-Улз голын сав газрын захиргаа дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 208,416.5 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 4,168.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Онон-Улз голын сав газрын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,803.5 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	3,443.2	3,650.0	206.8
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	8,571.4	9,361.3	789.9
Үндсэн хөрөнгө	74,823.0	67,022.9	-7,800.1

Нийт хөрөнгө	86,837.7	80,034.2	-6,803.5
Өр төлбөр	-	2,886.7	2,886.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	86,837.7	77,147.5	-9,690.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	86,837.7	80,034.2	-6,803.5

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс суутгасан ХХОАТ-ын 555.3 мянган төгрөгийн авлагаас татварт төлөх 348.5 мянган төгрөгийн өр суутгагдаж авлагын эцсийн үлдэгдэл 3650,0 мянган төгрөг болсон.

Бараа материалын дансны үлдэгдэл 9,361.3 мянган төгрөг болж 789.9 мянган төгрөгөөр өссөн нь 9,793.9 мянган төгрөгийн худалдан авалт хийж 9,004.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 67,022.9 мянган төгрөг болж 7,800.1 мянган төгрөгөөр буурсан нь 1,959.5 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл орлогод авч 9,759.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,886.7 мянган төгрөг байгаа нь цалингийн өглөг 2,331.4 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг үүсгэсэнтэй холбоотой хөгжлийн бэрхшээлтэй ажилчдад буцаан олгох 555.3 мянган төгрөгийн өглөгтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 77,147.5 мянган төгрөг болж 9,690.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Онон-Улз голын сав газрын захиргаа санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 41,381.4 мянган төгрөгөөр буюу 26.3 хувиар өссөн нь цалин, хөлс нэмэгдсэн, Хэнтий аймгийн БОАЖ-аас “Уст цэгийн тоо бүртгэлийн ажил гүйцэтгэх” 8,000.0 сая төгрөгийн гэрээний үнэ орж ирсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 27,564.7 мянган төгрөгөөр буюу 15.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, дотоод албан томилолтын зардал, түлш халаалтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, Хэнтий аймгийн БОАЖ-тай хамтарч уст цэгийн тоо бүртгэлийн ажил гүйцэтгэсэнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 190,554.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 190,554.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 3,832.8 мянган төгрөгөөр бууруулж 186,721.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 186,721.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 186,721.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 186,721.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 180,197.0 мянган төгрөгийг зарцуулж 6,524.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 180,197.0 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байгаа бусад нийтлэг ажил үйлчилгээ, төлбөрийн хураамж зардал 5,101.2 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 10,045.0 мянган төгрөгийн орлого орсон бөгөөд бичиг хэргийн зардалд 619.1 мянга, тээвэр шатахууны зардал 4,091.7 мянга, албан томилолтын зардалд 5,334.2 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 143 мэдээллээс 51 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1,300.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 3,400.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 2,300.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,300.0	1	1,300.0			
Албан шаардлага	1	3,400.0	1	3,400.0			
Зөвлөмж	1	2,300.0	1	2,300.0			
Нийт дүн	3	7,000.0	3	7,000.0			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 169,703.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 169,703.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн.

Залруулсан алдаа

Аудитаар хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос суутган тооцсон 555.3 мянган төгрөгийн ХХОАТ-ын зөрчилд залруулга хийж авлага, өглөг үүсгэсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 169,703.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

1. Тайлант онд шилэн дансанд байршуулбал зохих 143 мэдээллээс 51 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 3.1-д Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 3.1.1 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; 3.1.2 төрийн өмчит үйлдвэрийн газар; 6.1 Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: 6.1.1 тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор; 6.1.2 хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор; 6.1.3 дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.1.4 жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор 6.1.5 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор; 6.1.6 төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр мэдээлнэ гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг тус тус зөрчин хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос нийт 555.3 мянган төгрөгийн татвар суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх “дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2 дахь “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх “хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ...” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд нийт худалдан авалтынхаа 58.8 хувьд НӨАТ-ын баримт авсан нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг хэвлэнэ.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган тооцсон байна. Үүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан

татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Онон-Улз голын сав газрын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/111/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Онон-Улз голын сав газрын захиргаа		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансанд байршуулбал зохих 143 мэдээллээс 51 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн.	161,018.4	Албан шаардлага	Дарга нягтлан бодогч	Б.Баяртогтох Б.Цэндмаа
2	Нийт худалдан авалтынхаа 41.2 хувьд НӨАТ-ын баримт аваагүй.	8,129.7	Албан шаардлага	Дарга нягтлан бодогч	Б.Баяртогтох Б.Цэндмаа
3	Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос татвар суутган авсан.	555.3	Албан шаардлага өгөх	Дарга нягтлан бодогч	Б.Баяртогтох Б.Цэндмаа
ДҮН		169,703.4			

